



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 08

Мөрөн

Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Эх хэл бичиг” аймгийн дэд хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарч, санаачлага гарган ажиллахыг Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (С.Нарантуяа), Боловсрол, соёл урлагийн газрын дарга (Ц.Ганзориг)-нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

119120024

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 02 дугаар сарын 03-ны
өдрийн 02 тогтоолын хавсралт

“ЭХ ХЭЛ БИЧИГ” ХӨТӨЛБӨРТ ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 сарын 28-ны өдрийн 02-р дугаар тогтоолоор “Эх хэл, бичиг” хөтөлбөр батлагдсан. Уг батлагдсан хөтөлбөрт 4 зорилт тусгагдсан бөгөөд үндэсний цөөнхийн эх хэлний боловсролыг “Монгол хэлний тухай хууль”-д заасанчлан, цаатан иргэдийн Тува хэлний боловсролыг дэмжих, хадгалж хамгаалах, хэрэглээг нэмэгдүүлэх, бүх нийтийн цахим орчин дахь эх хэлний боловсрол, хэрэглээ, хандлагыг сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлагын үүднээс дараах 2 зорилтыг нэмэлтээр орууллаа. Үүнд:

ЗОРИЛТ 5. Тува иргэдийн хос хэлний боловсролыг дэмжих;

ЗОРИЛТ 6. Цахим орчин дахь эх хэлний соёл, хэрэглээний чадварын түвшинг дээшлүүлнэ;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5-р зорилтын хүрээнд:

3.5.1. Тува хэлтэн сурагчдын хос хэлний мэдлэг чадварын түвшинг судлах, ярих бичих чадварын түвшинг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах ажлын сум, орон нутгийн удирдлагуудын оролцоотойгоор зохион байгуулах

3.5.2. Тува хэлний багш бэлтгэх, багшийг мэргэшүүлэх, үндсэн сургалтад үе шаттай хамруулах /Тувад/

3.5.3. Сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

3.5.4. Цаатан иргэдийн Тува хэл, соёлын судалгааны ажлыг өргөжүүлэхэд сум, орон нутгаас санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөгжүүлэх

6-р зорилтын хүрээнд:

3.6.1. “Цахим орчин дахь эх хэлний соёл, хэрэглээ” судалгаа, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох

3.6.2. АУБ, Нийгмийн ажилтнууд “Цахим орчинд эх хэлээрээ зөв бичиж, хэвшицгээе” жишиг хичээлийн төлөвлөлт боловсруулах уралдаан зарлан шалгарсан хичээлийг турших

3.6.3. “Цахим орчин дахь эх хэлний соёл хэрэглээ, нөлөөлөл” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг, цуврал нэвтрүүлэг зохион байгуулна.

3.6.4. “Төрийн албан хаагчдын өврийн дэвтэр” найруулга зүй, зөв бичих дүрмийн эмхэтгэл ном бүтээх, хэрэглээ болгох